



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дархан-Уул аймгийн Дархан сумын 8 дугаар цэцэрлэг 2025 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

**Аудитын код:** ДАА-2026/68/НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a> Дархан-Уул аймаг 2026 он</p>	<p>Дарга, тэргүүлэх аудитор Ш.Мөнхбаяр: Утас: 70378845 Цахим хаяг: munkhbayarsh@audit.gov.mn</p> <p>Ахлах аудитор: С.Батцэцэг Утас: 70373089 Цахим хаяг: battsetsegs@audit.gov.mn</p> <p>Аудитор: Э.Эрдэнэбат Утас: 99352099 Цахим хаяг: tsesb.audit@gmail.com</p>
--	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



**ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Бурхантын гудамж-1, 14 дүгээр баг, Дархан сум,  
Дархан-Уул аймаг, 45059,  
Утас: 7037-3089, Факс: (976) 7037-3089  
Цахим шуудан: darhanuul@audit.gov.mn  
Цахим хуудас: www.audit.mn

2026.02.25 № 104

танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

ДАРХАН-УУЛ АЙМГИЙН 8 ДУГААР  
ЦЭЦЭРЛЭГИЙН ЭРХЛЭГЧ  
З.БАТХИШИГ ТАНАА

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дархан-Уул аймгийн Дархан сумын 8 дугаар цэцэрлэгийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дархан-Уул аймгийн Дархан сумын 8 дугаар цэцэрлэгийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцолсон хэсэг**

Тайлант хугацаанд аймгийн Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 6,090.0 мянган төгрөгийн зөөврийн компьютер, аймгийн Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар 19,800.0 мянган төгрөгийн гадаа талбайн багц тоглоом, цэцэрлэгийн эцэг, эхийн хандиваар авсан 4,548.0 мянган төгрөгийн хөрөнгүүдийг холбогдох дансанд бүртгэж, тайлагнасан байна.

**Аудитын гол асуудал**

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

4526050128

Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 238 дугаар тогтоолоор төрийн албан хаагчдын цалингийн хэмжээг нэмэгдүүлснээр цалин хөлс, нэмэгдэл урамшууллын зардал 758,098.7 мянган төгрөг болж өнгөрсөн оны гүйцэтгэлээс 30.5 хувиар өссөн байна.

#### **Бусад асуудлын хэсэг**

Дархан-Уул аймгийн Дархан сумын 8 дугаар цэцэрлэгийн 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 8 зорилтын хүрээнд 26 арга хэмжээ төлөвлөж, хэрэгжилтийг 98 хувиар тайлагнасан байна. Мөн улирал бүр аймгийн Боловсролын газарт ажлын тайланг хүргүүлж тайлагнасан байна.

#### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

#### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ш.МӨНХБАЯР

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Балансын зүйл	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>135,743,050.11</b>	<b>122,159,864.33</b>
<b>31</b>	<b>Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгө</b>	<b>98,906,532.77</b>	<b>24,332,566.59</b>
<b>311</b>	<b>Кассанд байгаа</b>	-	
<b>312</b>	<b>Банкинд байгаа</b>	98,906,532.77	24,332,566.59
<b>3121</b>	<b>Төгрөг</b>	98,906,532.77	24,332,566.59
31211	Төрийн сангийн харилцах	98,906,532.77	24,332,566.59
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	-	-
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	<b>36,836,517.34</b>	<b>97,827,297.74</b>
<b>351</b>	<b>Түүхий эд материал</b>	<b>857,500.00</b>	<b>134,150.00</b>
35130	Эм боох материал	857,500.00	134,150.00
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	<b>35,979,017.34</b>	<b>97,693,147.74</b>
35410	Бичиг хэргийн материал	28,500.00	72,000.00
35420	Аж ахуйн материал	18,491,513.00	74,040,625.30
35460	Хүнсний материал	6,762,303.99	7,639,402.09
35470	Бусад хангамжийн материал	10,696,700.35	15,941,120.35
<b>36</b>	<b>НӨӨЦИЙН БАРАА</b>		
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>1,576,890,006.08</b>	<b>1,573,943,361.33</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	<b>1,576,890,006.08</b>	<b>1,573,943,361.33</b>
<b>392</b>	<b>Биет хөрөнгийн дүн</b>	<b>1,379,185,256.10</b>	<b>1,376,581,111.39</b>
39201	Барилга байгууламж	1,345,636,000.00	1,345,636,000.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(73,069,371.96)	(95,552,255.64)
39205	Машин тоног төхөөрөмж	60,511,320.00	79,786,090.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(14,348,614.24)	(21,836,887.17)
39207	Тавилга, эд хогшил	69,446,493.00	56,395,710.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(33,752,197.93)	(26,237,247.97)
39214	Бусад үндсэн хөрөнгө	31,542,353.60	46,458,518.60
39215	Хуримтлагдсан элэгдэл	(8,010,228.67)	(8,068,816.43)
39217	Ном	1,229,502.30	-
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгийн дүн</b>	<b>197,704,749.98</b>	<b>197,362,249.94</b>
39301	Программ хангамж	1,870,000.00	1,870,000.00
39302	Хасагдуулга	(171,250.02)	(513,750.06)
39303	Бусад биет бус хөрөнгө	196,006,000.00	196,006,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>1,712,633,056.19</b>	<b>1,696,103,225.66</b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	-	-
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	-	-
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>1,712,633,056.19</b>	<b>1,696,103,225.66</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	<b>1,712,633,056.19</b>	<b>1,696,103,225.66</b>
511	Засгийн газрын оруулсан капитал	196,006,000.00	196,006,000.00
512	Хуримтлагдсан үр дүн	<b>1,508,391,848.29</b>	<b>1,491,862,017.76</b>
51210	Өмнөх үеийн үр дүн	1,508,391,848.29	1,508,391,848.29
51220	Тайлант үеийн үр дүн	-	(16,529,830.53)
513	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	8,235,207.90	8,235,207.90
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР БА ЭЗ/ӨМЧИЙН ДҮН</b>	<b>1,712,633,056.19</b>	<b>1,696,103,225.66</b>

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН</b>	<b>928,190,280.00</b>	<b>1,117,509,435.30</b>
12	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>23,283,780.00</b>	<b>128,043,635.30</b>
120	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>23,283,780.00</b>	<b>128,043,635.30</b>
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,535,280.00	846,720.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	21,748,500.00	50,171,600.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	-	77,025,315.30
13	<b>ТУСЛАМЖ САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>904,906,500.00</b>	<b>989,465,800.00</b>
1310	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	<b>813,469,200.00</b>	<b>917,299,700.00</b>
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	813,469,200.00	917,299,700.00
131103	ЗГНХ, Засаг даргын нөөц хөрөнгө түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөнөөс	2,000,000.00	
1320	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>89,437,300.00</b>	<b>72,166,100.00</b>
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	89,437,300.00	72,166,100.00
2	<b>Үйл ажиллагааны зардал</b>	<b>887,769,972.04</b>	<b>1,122,335,438.49</b>
21	<b>Урсгал зардал</b>	<b>887,769,972.04</b>	<b>1,122,335,438.49</b>
210	<b>Бараа, үйлчилгээний зардал</b>	<b>869,732,223.24</b>	<b>1,108,828,494.91</b>
2101	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшуулал</b>	<b>580,533,404.97</b>	<b>758,098,696.18</b>
210101	Үндсэн цалин	395,253,344.58	493,515,988.18
210102	Нэмэгдэл цалин	167,334,697.39	210,427,219.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	-	26,781,000.00
210104	Урамшуулал	17,945,363.00	27,374,489.00
2102	<b>Нийгмийн даатгалын шимтгэл</b>	<b>72,961,826.84</b>	<b>95,988,100.00</b>
210201	Тэтгэврийн даатгалын	50,322,243.24	65,080,400.00
210202	тэтгэмжийн даатгалын	5,868,419.44	7,726,900.00
210203	ҮОМШӨ-ий даатгалын	2,920,860.10	3,863,500.00
210204	Ажилгүйдлийн даатгалын	2,769,963.48	3,863,500.00
210205	ЭМ-ийн даатгалын	11,080,340.58	15,453,800.00
2103	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>71,411,931.20</b>	<b>55,226,056.42</b>
210301	Гэрэл цахилгааны зардал	12,746,618.76	17,755,973.44
210302	Түлш, халаалтын зардал	51,799,440.00	31,344,303.76
210303	Цэвэр бохир усны зардал	6,865,872.44	6,125,779.22
2104	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>9,598,858.77</b>	<b>12,374,003.00</b>
210401	Бичиг хэргийн зардал	3,934,800.00	5,065,800.00
210406	Бараа материал акталсны зардал	5,664,058.77	7,308,203.00
2105	<b>Нормативт зардал</b>	<b>76,779,153.10</b>	<b>81,548,821.90</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлэгийн хэрэгсэл	212,976.50	116,180.00
210502	Хоол, хүнс	76,566,176.60	81,432,641.90

<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>14,505,300.00</b>	<b>10,307,020.00</b>
210604	Урсгал засварын зардал	14,505,300.00	10,307,020.00
<b>2107</b>	<b>Томилолтын зардал</b>	-	-
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажлын хөлс</b>	<b>1,167,500.00</b>	<b>2,765,200.00</b>
210806	Мэдээлэл технологийн үйлчилгээ	1,167,500.00	2,765,200.00
<b>2109</b>	<b>Бараа, үйлчилгээний бусад зардал</b>	<b>42,774,248.36</b>	<b>92,520,597.41</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	18,780,159.16	48,628,480.00
210902	Хичээл сургалт, үйлдвэрлэлийн дадлагын зардал	3,512,800.00	2,477,700.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	20,481,289.20	41,414,417.41
<b>213</b>	<b>Урсгал шилжүүлэг</b>	<b>18,037,748.80</b>	<b>13,506,943.58</b>
	Бусад урсгал шилжүүлэг	12,982,400.00	6,389,600.00
	Нэг удаагийн тэтгэмж шагнал урамшуулал	12,982,400.00	6,389,600.00
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	<b>5,055,348.80</b>	<b>7,117,343.58</b>
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	5,055,348.80	7,117,343.58
<b>3</b>	<b>Үйл ажиллагааны үр дүн</b>	<b>40,420,307.96</b>	<b>(4,826,003.19)</b>
<b>145</b>	<b>Үйл ажиллагааны бус орлогын дүн</b>		
<b>225</b>	<b>Үйл ажиллагааны бус зардлын дүн</b>		<b>11,703,827.34</b>
<b>225</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>		<b>11,703,827.34</b>
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз		11,703,827.34
<b>4</b>	<b>Үйл ажиллагааны бус үр дүн</b>	-	(11,703,827.34)
<b>5</b>	<b>Үйл ажиллагааны нийт үр дүн</b>	<b>40,420,307.96</b>	<b>(16,529,830.53)</b>

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН</b>	<b>906,441,780.00</b>	<b>990,312,520.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>1,535,280.00</b>	<b>20,132,420.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>1,535,280.00</b>	<b>20,132,420.00</b>
120002	Хүүгийн орлого		
<b>120004</b>	<b>Төсөвт байгууллагын өөрийн орлого</b>	<b>1,535,280.00</b>	<b>20,132,420.00</b>
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,535,280.00	20,132,420.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>904,906,500.00</b>	<b>970,180,100.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	<b>813,469,200.00</b>	<b>898,014,000.00</b>
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	813,469,200.00	898,014,000.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	-	
		2,000,000.00	
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	-	-
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>89,437,300.00</b>	<b>72,166,100.00</b>
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	89,437,300.00	72,166,100.00
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>855,428,067.31</b>	<b>1,064,886,486.18</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>855,428,067.31</b>	<b>1,064,886,486.18</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>837,390,318.51</b>	<b>1,051,379,542.60</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшуулал</b>	<b>580,533,404.97</b>	<b>758,098,696.18</b>
210101	Үндсэн цалин	395,253,344.58	493,515,988.18
210102	Нэмэгдэл	167,334,697.39	210,427,219.00
210103	Хоол унаа хөнгөлөлт		26,781,000.00
210104	Урамшуулал	17,945,363.00	27,374,489.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчийн нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>72,961,826.84</b>	<b>95,988,100.00</b>
210201	Тэтгэврийн даатгалын	50,322,243.24	65,080,400.00
210202	Тэтгэмжийн даатгалын	5,868,419.44	7,726,900.00
210203	ҮОМШӨ-ий даатгалын	2,920,860.10	3,863,500.00
210204	Ажилгүйдлийн даатгалын	2,769,963.48	3,863,500.00
210205	Эрүүл мэндийн даатгалын	11,080,340.58	15,453,800.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>71,411,931.20</b>	<b>55,226,056.42</b>
210301	Гэрэл цахилгааны зардал	12,746,618.76	17,755,973.44
210302	Түлш, халаалтын зардал	51,799,440.00	31,344,303.76
210303	Цэвэр бохир усны зардал	6,865,872.44	6,125,779.22
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материал</b>	-	-
210401	Бичиг хэргийн зардал		
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>75,857,648.00</b>	<b>82,309,740.00</b>
210502	Хоол, хүнс	75,857,648.00	82,309,740.00
<b>2106</b>	<b>Эд хогшил урсгал засвар</b>	<b>14,505,300.00</b>	<b>10,669,420.00</b>
210604	Урсгал засвар	14,505,300.00	10,669,420.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	-	-
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажлын, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>2,377,300.00</b>	<b>2,985,200.00</b>
210806	Мэдээлэл технологийн үйлчилгээ	2,377,300.00	2,985,200.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>19,742,907.50</b>	<b>46,102,330.00</b>

210901	Бараа үйлчилгээний бусад зардал	12,421,307.50	40,865,030.00
210902	Хичээл, үйлдвэрлэлийн дадлага хийх	7,321,600.00	5,237,300.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>18,037,748.80</b>	<b>13,506,943.58</b>
	Бусад урсгал шилжүүлэг	12,982,400.00	6,389,600.00
	Нэг удаагийн тэтгэмж урамшуулал	12,982,400.00	6,389,600.00
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	<b>5,055,348.80</b>	<b>7,117,343.58</b>
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	5,055,348.80	7,117,343.58
<b>22</b>	<b>Хөрөнгийн зардал</b>	-	-
<b>2220</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	-	-
225108	Бусад хөрөнгө		
<b>3</b>	<b>Үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ</b>	<b>51,013,712.69</b>	<b>(74,573,966.18)</b>
<b>4</b>	<b>Хөрөнгө оруулалтын мөнгөн орлогын дүн</b>		
<b>5</b>	<b>Хөрөнгө оруулалтын мөнгөн зарлагын дүн</b>		-
<b>22</b>	<b>Хөрөнгийн зардал</b>	-	-
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>		-
223001	Бусад хөрөнгө	(8,076,900.00)	
<b>6</b>	<b>Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ</b>	<b>(8,076,900.00)</b>	-
<b>7</b>	<b>Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>		
<b>8</b>	<b>Нийт цэвэр мөнгөн гүйлгээ</b>	<b>42,936,812.69</b>	<b>(74,573,966.18)</b>
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	55,969,720.08	98,906,532.77
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		24,332,566.59

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	Засгийн газрын хувь оролцооны үр дүн
А	1	2	3	4
<b>2024 оны 01 дүгээр сарын 01-нээрх үлдэгдэл</b>	<b>196,006,000.00</b>	<b>8,235,207.90</b>	<b>1,508,391,848.29</b>	<b>1,712,633,056.19</b>
НББ-ийн бодлогын өөрчлөлт				-
Дахин илэрхийлсэн үлдэгдэл				-
ҮХ-ийн өсөлт, бууралт				-
ҮХ-ийн дахин үнэлгээний өсөлт, бууралт				-
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				-
Тайлант үеийн үр дүн			(19,424,002.26)	<b>(19,424,002.26)</b>
<b>2024 оны 12 дугаар сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>196,006,000.00</b>	<b>8,235,207.90</b>	<b>1,508,391,848.29</b>	<b>1,712,633,056.19</b>
НББ-ийн бодлогын өөрчлөлт			-	-
ҮХ-ийн өсөлт, бууралт		-		-
ҮХ-ийн дахин үнэлгээний бууралт				-
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				-
Тайлант үеийн үр дүн			(16,529,830.53)	<b>(16,529,830.53)</b>
<b>2025 оны 12 дугаар сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>196,006,000.00</b>	<b>8,235,207.90</b>	<b>1,491,862,017.76</b>	<b>1,696,103,225.66</b>

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Д/Д	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		-		
2	Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	1,107,262,000.00	1,057,769,142.60	49,492,857.40	95.5
21	Урсгал зардлын дүн	1,107,262,000.00	1,057,769,142.60	49,492,857.40	95.5
210	Бараа үйлчилгээний зардал	1,100,872,400.00	1,051,379,542.60	49,492,857.40	95.5
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	772,689,500.00	758,098,696.18	14,590,803.82	98.1
210101	Үндсэн цалин	507,314,100.00	493,515,988.18	13,798,111.82	97.3
210102	Нэмэгдэл	246,246,500.00	210,427,219.00	35,819,281.00	85.5
210103	Унаа хоолны хөнгөлөлт		26,781,000.00	(26,781,000.00)	
210104	Урамшуулал	19,128,900.00	27,374,489.00	(8,245,589.00)	143.1
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	95,988,100.00	95,988,100.00	-	100.0
210201	Тэтгэврийн даатгал	65,080,400.00	65,080,400.00	-	100.0
210202	Тэтгэмжийн даатгал	7,726,900.00	7,726,900.00	-	100.0
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,863,500.00	3,863,500.00	-	100.0
210204	Ажилгүйдлийн даатгал	3,863,500.00	3,863,500.00	-	100.0
210205	ЭМД-ын хураамж	15,453,800.00	15,453,800.00	-	100.0
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	82,506,200.00	55,226,056.42	27,280,143.58	66.9
210301	Гэрэл цахилгааны зардал	19,775,000.00	17,755,973.44	2,019,026.56	89.8
210302	Түлш, халаалтын зардал	49,929,600.00	31,344,303.76	18,585,296.24	62.8
210303	Цэвэр бохир усны зардал	12,801,600.00	6,125,779.22	6,675,820.78	47.9
2104	Хангамж, бараа материалын зардал	-	-	-	
210401	Бичиг хэрэг		-	-	
2105	Нормативт зардал	89,722,200.00	82,309,740.00	7,412,460.00	91.7
210502	Хоол хүнс	89,722,200.00	82,309,740.00	7,412,460.00	91.7
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	10,669,500.00	10,669,420.00	80.00	100.0
210604	Урсгал засвар	10,669,500.00	10,669,420.00	80.00	100.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр	3,767,100.00	2,985,200.00	781,900.00	79.2
210806	Мэдээлэл технологийн үйлчилгээ	3,767,100.00	2,985,200.00	781,900.00	79.2

2109	Бараа үйлчилгээний бусад зардал	45,529,800.00	46,102,330.00	(572,530.00)	101.3
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	38,570,400.00	39,142,930.00	(572,530.00)	101.5
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	6,959,400.00	6,959,400.00	-	100.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	6,389,600.00	6,389,600.00	-	100.0
1	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,107,262,000.00	983,195,176.42	124,066,823.58	88.8
131	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,014,086,300.00	898,014,000.00	116,072,300.00	88.6
131001	Улсын төсвөөс санхүүжих	1,014,086,300.00	898,014,000.00	116,072,300.00	88.6
132	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	93,175,700.00	65,048,756.42	28,126,943.58	69.8
132001	Орон нутгийн төсвөөс	93,175,700.00	65,048,756.42	28,126,943.58	69.8
			-	-	
	Төсвийн захирагчдаас			-	
120004	Төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас	20,185,700.00	20,132,420.00	53,280.00	99.7
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	20,185,700.00	20,132,420.00	53,280.00	99.7
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		98,906,532.77		
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		24,332,566.59	24,332,566.59	
001	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ			-	
002	БАЙГУУЛЛАГЫН ТОО			-	
003	Төсвийн байгууллага	1.00	1.00	-	100.0
	АЖИЛЛАГСАДЫН ТОО	35.00	35.00	-	100.0
	Удирдах ажилтан	1.00	1.00	-	100.0
	Гүйцэтгэх ажилтан	27.00	27.00	-	100.0
	Үйлчлэх ажилтан	7.00	7.00	-	100.0

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 3,253.6 мянган төгрөгийн зөрчил<sup>1</sup> илэрсэн тул төсвийг хохиролгүй болгох 800.0 мянган төгрөгийн 2 төлбөрийн акт, 2,453.6 мянган төгрөгийн 1 албан шаардлага хүргүүлээ.

### 5.1 Төлбөрийн акт

**5.1.1 Илрүүлэлт:** Тайлант онд тус сургуулийн хичээл сургалт, үйлдвэрлэлийн дадлагын зардлаас хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сургалтад хамрагдсан эрхлэгч Г.Энхтулгад сургалтын төлбөрт 600.0 мянган төгрөг төлж, батлагдсан төсвийг үр ашиггүй зарцуулсан байна.

Энэ нь нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй төлөвлөж, зарцуулах”, 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь “Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 39 дүгээр тогтоолоор баталсан “Хувьсах зардал болон гүйцэтгэл, үр дүнд суурилан санхүүжүүлэх журам”-ын хавсралт “Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын сургуулийн нэг суралцагчид ногдох хувьсах зардлын хэмжээний бүрэлдэхүүн, зардлын зориулалт, эдийн засгийн ангиллын дэлгэрэнгүй заавар”-ын 7-д “Багшийн тасралтгүй хөгжлийг дэмжих зардал (Боловсролын байгууллагын багш, ажилтны мэргэжил дээшлүүлэх) буюу Багшийн хөгжил буюу мэргэжил дээшлүүлэх зардалд цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн багш, ажилтны хөгжих хэрэгцээнд суурилсан цахим платформд түшиглэн явуулах тусгай сургалт (1, 5, 10 жилийн сургалтаас бусад), бусад сургалт үйл ажиллагааны зардал багтана.” гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

**5.1.2 Илрүүлэлт:** Тус цэцэрлэгийн эрхлэгч З.Батхишигт хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудал хариуцан ажилласны нэмэгдэл хөлсийг гүйцэтгэсэн ажил үүрэгт нь тохирох цалин хөлсийг олгоогүйгээс нийт 200.0 мянган төгрөг илүү олгож, төсвийг үр ашиггүй зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй төлөвлөж, зарцуулах” 16 дугаар зүйлийн 16.5.5-д “Батлагдсан төсвийн зориулалтын дагуу зарцуулах”, Хөдөлмөрийн тухай хуулийн 56 дугаар зүйлийн 56.1-д “Ажил олгогч нь ажилтантай тохиролцсоноор ажил хослон гүйцэтгүүлэх, эзгүй байгаа ажилтны үүргийг түр орлон гүйцэтгүүлэх, ажилтны ажлын цагт багтаан өөр ажил, албан тушаал хавсран гүйцэтгүүлэх, ажлын ачааллыг нэмэгдүүлэх хэлбэрээр ажиллуулж болно”, 56.2-т “Энэ хуулийн 56.1-д заасны дагуу ажиллах ажилтанд гүйцэтгэх ажил үүрэгт нь тохирох цалин хөлсийг нэмж олгоно” гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

### 5.2 Албан шаардлага

**5.2.1.Илрүүлэлт:** Тайлант онд тус цэцэрлэгийн эрхлэгч З.Батхишиг нь Дархан-Уул аймгийн Боловсролын газрын даргын 2025 оны А/94 дүгээр тушаалыг үндэслэн хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудал хариуцан ажилласны нэмэгдэл цалин хөлсөнд нийт 2,453.6 мянган төгрөг авч, хууль тогтоомжийн хүрээнд хяналт тавих чиг үүргээ хэрэгжүүлээгүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1-д “Төсвийн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг удирдах”, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1-д “Хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангах,

<sup>1</sup> Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/

*хөдөлмөрийн нөхцөлийг сайжруулах, хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, хяналт тавих үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын захирал /эзэн/, ажил олгогч шууд хариуцна", 27.6-д "Аж ахуйн нэгж, байгууллагын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудал хариуцсан бүтцийн жишиг, ажилтны орон тооны норматив, зөвлөлийн ажиллах үлгэрчилсэн журмыг хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага батална", Хөдөлмөрийн сайдын 2015 оны А/114 дүгээр тушаалын 1.В дэх хэсэгт "Төрийн болон төрийн үйлчилгээний төсвийн байгууллага ажилтны тооноос хамаарахгүйгээр Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудлыг аль нэг ажилтанд хавсран хариуцуулна. Хавсран ажиллуулсан тохиолдолд Хөдөлмөрийн тухай хуулийн 50 дугаар зүйлд заасны дагуу үндсэн ажлын цалингийн 40 хүртэлх хувийн нэмэгдэл хөлс олгоно" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.*

### **5.3 Зөвлөмж**

Санхүүгийн тайлагналтай холбоотой өгсөн зөвлөмж байхгүй.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		/мянган төгрөгөөр/				Зөвлөмж	
							Үүнээс					
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
<b>Дүн</b>	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		/мянган төгрөгөөр/									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Тайлант онд тус цэцэрлэгийн эрхлэгч З.Батхишиг хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудал хариуцан ажилласны нэмэгдэл цалин хөлсийг ТҮ-7 тооцон олгоогүй байна.	1	200.0	1	200.0	-	-	-	-	-	-	-	-
Тайлант онд тус цэцэрлэгийн хичээл сургалт, үйлдвэрлэлийн дадлагын зардлаас хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сургалтад хамрагдсан эрхлэгч Г.Энхтулгад олгосон байна.	1	600.0	1	600.0	-	-	-	-	-	-	-	-
Тайлант онд тус цэцэрлэгийн эрхлэгч З.Батхишиг нь Дархан-Уул аймгийн Боловсролын газрын даргын 2025 оны А/94 дүгээр тушаалыг үндэслэн хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудал хариуцан ажилласны нэмэгдэл цалин хөлс олгосон байна	1	2,453.6			1	2,453.6						
<b>Дүн</b>	<b>3</b>	<b>3,253.6</b>	<b>2</b>	<b>800.0</b>	<b>1</b>	<b>2,453.6</b>			-	-	-	-

